

## МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬД ГАДААДЫН ИРГЭНИЙГ СУРАЛЦУУЛАХ ЖУРАМ<sup>1</sup>

### 1. Ерөнхий зүйл

- 1.1. Монгол Улсын Их Сургууль (МУИС)-ийн боловсролын зэрэг олгох хөтөлбөр, оюутан солилцооны хөтөлбөр /боловсролын зэрэг олгохгүй/, Монгол хэлний бэлтгэл хөтөлбөрт гадаадын иргэдийг суралцуулах, гадаадын иргэнийг МУИС-д мэргэжил дээшлүүлэх, судлаачаар ажиллуулахад БСШУ-ы сайдын 2001/113 тоот тушаалаар баталсан “Монгол улсын дээд боловсролын байгууллагад гадаадын иргэдийг суралцуулах журам” болон энэхүү журмыг баримтална.
- 1.2. МУИС-д суралцах, мэргэжил дээшлүүлэх гадаадын иргэн болон МУИС-ийн холбогдох нэгжүүдийн үйл ажиллагааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.
- 1.3. Бакалаврын зэрэг олгох хөтөлбөрт элсэлтийг хичээлийн жилд нэг удаа, магистр, докторын зэрэг олгох хөтөлбөр, оюутан солилцооны хөтөлбөр болон Монгол хэлний бэлтгэл хөтөлбөрт элсэлтийг хичээлийн жилд хоёр удаа зохион байгуулна.

### 2. Элсэн суралцах гадаадын иргэнд тавих шаардлага

- 2.1. *Иргэнийг.* Монгол улсын харьяат бус гадаадын иргэн хаана оршин суугаагаас үл хамааран энэ журмын хүрээнд МУИС-д суралцах, мэргэжил дээшлүүлэх, судлаачаар ажиллах хүсэлт гаргаж болно.
- 2.2. *Боловсрол.*
  - 2.2.1. *Боловсролын зэрэг.* Боловсролын зэрэг олгох хөтөлбөрт суралцах, МУИС-д мэргэжил дээшлүүлэх, судлаачаар ажиллах гадаадын иргэн Монгол улсад мөрдөгдөж буй боловсролын агуулгын түвшин, стандарттай дүйцэхүйц өмнөх шатны боловсрол эзэмшсэн байна. Үүнийг Монгол хэлний бэлтгэл хөтөлбөр<sup>2</sup>-т элсэн суралцах гадаадын иргэнээс шаардахгүй боловч тухайн хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй гадаадын иргэн 18 нас хүрсэн, хууль эрх зүйн хувьд өөрийгөө хариуцах бүрэн чадамжтай байна.
  - 2.2.2. *Монгол хэлний мэдлэг, чадвар.*
    - 2.2.2.1. Боловсролын зэрэг олгох монгол хэлээр сургалт нь явагддаг хөтөлбөрт элсэх, оюутан солилцоогоор суралцах гадаадын иргэн монгол хэлийг шаардлага хангасан түвшинд эзэмшсэн байх ёстой ба үүнийг нотлох диплом, гэрчилгээний хуулбарыг элсэх, суралцах хүсэлт гаргах үед ирүүлнэ. Нотлох бичиг баримт байхгүй бол монгол хэлний бэлтгэл хөтөлбөр /хичээлийн жилийн турш зохион байгуулагддаг бүрэн курс, нэг улирлын хугацаанд зохион байгуулагддаг бүрэн бус курс/-т хамрагдаад амжилттай төгссөний дараа боловсролын зэрэг олгох хөтөлбөрт элсэн суралцахаар хүсэлт гаргаж болно.
    - 2.2.2.2. Боловсролын зэрэг олгох англи хэлээр сургалт нь явагддаг, бусад их сургууль байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй хөтөлбөрт элсэх, оюутан солилцоогоор суралцах, МУИС-д мэргэжил дээшлүүлэх, судлаачаар ажиллах гадаадын иргэнээс монгол хэлний мэдлэг, чадвартай байхыг шаардахгүй боловч тухайн хөтөлбөрийн шаардлагад нийцсэн түвшний англи хэлний мэдлэг, чадвартай байхыг шаардана.

<sup>1</sup> МУИС-ийн захирлын 2012 оны 348 дугаар тушаалаар баталж, 2014 оны ... дугаар тушаалаар өөрчлөлт оруулсан журмын шинэчилсэн найруулга

<sup>2</sup> Гадаадын иргэнийг Монгол хэлний бэлтгэл хөтөлбөрт элсүүлэн суралцуулах журмыг Монгол хэл, соёлын сургууль тусад нь гаргаж, мөрдүүлнэ.

- 2.3. *Бусад*. Гадаадын иргэний элсэх, суралцах хүсэлт гаргаж буй хөтөлбөрийг хариуцсан бүрэлдэхүүн сургууль, мэргэжлийн тэнхим/профессорын багаас тавьсан бусад тусгай шаардлагыг хангах.

### 3. Элсэх, суралцах хүсэлт гаргах

- 3.1. МУИС-ийн боловсролын зэрэг олгох хөтөлбөр, монгол хэлний бэлтгэл хөтөлбөр болон оюутан солилцооны хөтөлбөрт хамрагдан суралцах хүсэлтэй гадаадын иргэн тухайн хөтөлбөр харьяалагдах бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын албанд, харин МУИС-д мэргэжил дээшлүүлэх, судлаачаар ажиллах гадаадын иргэн МУИС-ийн Гадаад харилцааны хэлтэст <http://burtgel.num.edu.mn> хаягаар цахим хэлбэрээр хүсэлт гаргаж, бүртгүүлнэ.
- 3.2. Элсэх, суралцах тухай хүсэлтийг заасан хугацаанд багтаж гаргасан байна. Үүнд:
- Бакалаврын зэрэг олгох, монгол хэлээр сургалт нь явагддаг хөтөлбөрт элсэх тухай хүсэлтийг 3 дугаар сарын 15-наас 5 дугаар сарын 15-ны хооронд гаргаж, бүртгүүлнэ.
  - Магистр, докторын зэрэг олгох, Монгол хэлний бэлтгэл хөтөлбөрт элсэх, МУИС-д мэргэжил дээшлүүлэх, судлаачаар ажиллах тухай хүсэлтийг намрын улиралд суралцах бол 3 дугаар сарын 15-наас 5 дугаар сарын 15-ны хооронд, хаврын улиралд суралцах бол 9 дүгээр сарын 1-нээс 11 дүгээр сарын 1-ний хооронд тус тус гаргаж бүртгүүлнэ.
  - Боловсролын зэрэг олгох англи хэлээр сургалт нь явагддаг хөтөлбөрт элсэх, оюутан солилцоогоор суралцах тухай хүсэлтийг уг хөтөлбөрийн журамд заасан хугацаанд багтаан /тухайн хөтөлбөр харьяалагдах бүрэлдэхүүн сургуулийн цахим хуудаснаас эсвэл Сургалтын албанд нь хандан тодруулах/ гаргана.
- 3.3. Дээр дурьдсан хугацаанаас хэтрүүлэн гаргасан өргөдлийг хүлээн авахгүй.
- 3.4. Элсэх, суралцах тухай өргөдөл гаргахад <http://burtgel.num.edu.mn> цахим хуудсанд байршуулсан өргөдлийн маягтыг бөглөж, дараах бичиг баримтуудын эх хувийг цахим хэлбэрээр хавсаргана. Үүнд:

| Хөтөлбөр                           | Монгол хэлний бэлтгэл                                                                                                                                                                                 | Бакалавр                                                                                                                                                                                              | Магистр<br>Судлаачаар<br>ажиллах                                                                                                                                                                      | Доктор                                                                                                                                                                                                |
|------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Бүртгэлд хавсаргах бичиг баримтууд | Өмнө нь эзэмшсэн боловсролын түвшинг илтгэх диплом /гэрчилгээ, дүнгийн хавсралтын хамт /монгол эсвэл англи хэлнээс өөр хэлээр бичигдсэн бол эдгээр хэлний аль нэг рүү нь орчуулсан байх шаардлагатай/ | Өмнө нь эзэмшсэн боловсролын түвшинг илтгэх диплом/ гэрчилгээ, дүнгийн хавсралтын хамт /монгол эсвэл англи хэлнээс өөр хэлээр бичигдсэн бол эдгээр хэлний аль нэг рүү нь орчуулсан байх шаардлагатай/ | Өмнө нь эзэмшсэн боловсролын түвшинг илтгэх диплом/ гэрчилгээ, дүнгийн хавсралтын хамт /монгол эсвэл англи хэлнээс өөр хэлээр бичигдсэн бол эдгээр хэлний аль нэг рүү нь орчуулсан байх шаардлагатай/ | Өмнө нь эзэмшсэн боловсролын түвшинг илтгэх диплом/ гэрчилгээ, дүнгийн хавсралтын хамт /монгол эсвэл англи хэлнээс өөр хэлээр бичигдсэн бол эдгээр хэлний аль нэг рүү нь орчуулсан байх шаардлагатай/ |

|  |                                                                                                                                                                               |                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                                                                                                                                                                                                                                                                         |
|--|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|  | Гадаадын иргэн болохыг нотлох албан ёсны баримт бичиг /гадаад паспорт гэх мэт/                                                                                                | Гадаадын иргэн болохыг нотлох албан ёсны баримт бичиг /гадаад паспорт гэх мэт/                                                                                                | Гадаадын иргэн болохыг нотлох албан ёсны баримт бичиг /гадаад паспорт гэх мэт/                                                                                                                                                                                                                                          | Гадаадын иргэн болохыг нотлох албан ёсны баримт бичиг /гадаад паспорт гэх мэт/                                                                                                                                                                                                                                          |
|  |                                                                                                                                                                               |                                                                                                                                                                               | Монгол эсвэл англи хэлээр бичсэн судалгааны санал /2000-аас доошгүй үгтэй/                                                                                                                                                                                                                                              | Монгол эсвэл англи хэлээр бичсэн судалгааны санал /3000-аас доошгүй үгтэй/                                                                                                                                                                                                                                              |
|  | Өргөдөл гаргагчийн Монгол улсад суралцах эсвэл мэргэжил дээшлүүлэх хугацааны сургалтын төлбөр, амьдрах зардлыг хариуцах байгууллага, хувь хүнээс гаргасан санхүүгийн баталгаа | Өргөдөл гаргагчийн Монгол улсад суралцах эсвэл мэргэжил дээшлүүлэх хугацааны сургалтын төлбөр, амьдрах зардлыг хариуцах байгууллага, хувь хүнээс гаргасан санхүүгийн баталгаа | Өргөдөл гаргагчийн Монгол улсад суралцах эсвэл мэргэжил дээшлүүлэх хугацааны сургалтын төлбөр, амьдрах зардлыг хариуцах байгууллага, хувь хүнээс гаргасан санхүүгийн баталгаа                                                                                                                                           | Өргөдөл гаргагчийн Монгол улсад суралцах эсвэл мэргэжил дээшлүүлэх хугацааны сургалтын төлбөр, амьдрах зардлыг хариуцах байгууллага, хувь хүнээс гаргасан санхүүгийн баталгаа                                                                                                                                           |
|  |                                                                                                                                                                               |                                                                                                                                                                               | Өргөдөл гаргагчийн мэдлэг боловсрол, ажлын туршлага, суралцах арга барилыг нь тодорхойлсон профессор багш болон удирдах ажилтны тодорхойлолт /өргөдөл гаргагчид <a href="http://burtgel.num.edu.mn">http://burtgel.num.edu.mn</a> цахим хуудсанд байршуулсан загварын дагуу энэ тодорхойлолтыг авсан байх шаардлагатай/ | Өргөдөл гаргагчийн мэдлэг боловсрол, ажлын туршлага, суралцах арга барилыг нь тодорхойлсон профессор багш болон удирдах ажилтны тодорхойлолт /өргөдөл гаргагчид <a href="http://burtgel.num.edu.mn">http://burtgel.num.edu.mn</a> цахим хуудсанд байршуулсан загварын дагуу энэ тодорхойлолтыг авсан байх шаардлагатай/ |

|                                                                                                                                                                                                              |                                                                                                                                                                                                              |                                                                                                                                                                                                              |                                                                                                                                                                                                              |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Өргөдөл гаргагчийн төрөлх хэл нь монгол хэл биш бол монгол, англи хэлний мэдлэг, чадварын түвшинг илтгэх баримт /сүүлийн хоёр жилийн хугацаанд хүчинтэй TOEFL, IELTS гэх мэт шалгалтын оноо бүхий гэрчилгээ/ | Өргөдөл гаргагчийн төрөлх хэл нь монгол хэл биш бол монгол, англи хэлний мэдлэг, чадварын түвшинг илтгэх баримт /сүүлийн хоёр жилийн хугацаанд хүчинтэй TOEFL, IELTS гэх мэт шалгалтын оноо бүхий гэрчилгээ/ | Өргөдөл гаргагчийн төрөлх хэл нь монгол хэл биш бол монгол, англи хэлний мэдлэг, чадварын түвшинг илтгэх баримт /сүүлийн хоёр жилийн хугацаанд хүчинтэй TOEFL, IELTS гэх мэт шалгалтын оноо бүхий гэрчилгээ/ | Өргөдөл гаргагчийн төрөлх хэл нь монгол хэл биш бол монгол, англи хэлний мэдлэг, чадварын түвшинг илтгэх баримт /сүүлийн хоёр жилийн хугацаанд хүчинтэй TOEFL, IELTS гэх мэт шалгалтын оноо бүхий гэрчилгээ/ |
| Эрүүл мэндийн баталгаа<br><a href="http://burtgel.num.edu.mn">/http://burtgel.num.edu.mn</a> цахим хуудсанд байршуулсан загварын дагуу дээрх бүртгэлийн хугацаанд эмнэлгээс олгосон байх/                    | Эрүүл мэндийн баталгаа<br><a href="http://burtgel.num.edu.mn">/http://burtgel.num.edu.mn</a> цахим хуудсанд байршуулсан загварын дагуу дээрх бүртгэлийн хугацаанд эмнэлгээс олгосон байх/                    | Эрүүл мэндийн баталгаа<br><a href="http://burtgel.num.edu.mn">/http://burtgel.num.edu.mn</a> цахим хуудсанд байршуулсан загварын дагуу дээрх бүртгэлийн хугацаанд эмнэлгээс олгосон байх/                    | Эрүүл мэндийн баталгаа<br><a href="http://burtgel.num.edu.mn">/http://burtgel.num.edu.mn</a> цахим хуудсанд байршуулсан загварын дагуу дээрх бүртгэлийн хугацаанд эмнэлгээс олгосон байх/                    |
| Цээж зураг /сүүлийн 3 сард авахуулсан, 3х4 хэмжээтэй байх/                                                                                                                                                   | Цээж зураг /сүүлийн 3 сард авахуулсан, 3х4 хэмжээтэй байх/                                                                                                                                                   | Цээж зураг /сүүлийн 3 сард авахуулсан, 3х4 хэмжээтэй байх/                                                                                                                                                   | Цээж зураг /сүүлийн 3 сард авахуулсан, 3х4 хэмжээтэй байх/                                                                                                                                                   |
| Тухайн хичээлийн жилд тогтоогдсон үйлчилгээний хураамжийг ам.доллар цахим хэлбэрээр МУИС-ийн дансанд тушаасан байх                                                                                           | Тухайн хичээлийн жилд тогтоогдсон үйлчилгээний хураамжийг ам.доллар цахим хэлбэрээр МУИС-ийн дансанд тушаасан байх                                                                                           | Тухайн хичээлийн жилд тогтоогдсон үйлчилгээний хураамжийг ам.доллар цахим хэлбэрээр МУИС-ийн дансанд тушаасан байх                                                                                           | Тухайн хичээлийн жилд тогтоогдсон үйлчилгээний хураамжийг ам.доллар цахим хэлбэрээр МУИС-ийн дансанд тушаасан байх                                                                                           |

Бусад /Хөтөлбөрийг хариуцсан бүрэлдэхүүн сургууль, мэргэжлийн тэнхим/профессорын баг шаардлагатай бол бусад бичиг баримт нэхэж болно./

- 3.5. Өргөдөл гаргагч өмнөх боловсролын диплом/гэрчилгээ, дүнгийн хавсралтын баталгаажуулсан хувийг төгссөн сургуулиасаа авч өөрийнх нь мэдлэг боловсрол, ажлын туршлага, суралцах арга барилыг тодорхойлсон профессор багш болон удирдах ажилтнаас өгсөн тодорхойлолтыг /хоёр/ гадаад хэлний мэдлэг чадварын түвшинг илтгэх баримт бичгийн эх хувийн хамт суралцах бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын албанд өргөдөл гаргах сүүлийн хугацаанд багтаан ирүүлнэ /шуудангаар эсвэл биеэр/.
- 3.6. МУИС хүлээн авсан бичиг баримтуудыг өргөдөл гаргагчид эргүүлж олгохгүй.

#### **4. Элсэгчийг шалгаруулах ба мэдэгдэх**

- 4.1. Хоёр улсын Засгийн газар хоорондын болон хоёр тал /МУИС ба гадаадын байгууллага, иргэн/-ын гэрээ, хэлэлцээрийн дагуу суралцах, мэргэжил дээшлүүлэх, судлаачаар ажиллах гадаадын иргэдийг БШУ-ны сайд, МУИС-ийн Захирлын тушаалаар шууд элсүүлэн суралцуулна.
- 4.2. Бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын алба холбогдох мэргэжлийн тэнхим/салбартай хамтран тухайн сургуульд суралцах хүсэлт гаргасан гадаадын иргэний өргөдлийг өргөдөл хүлээн авах сүүлийн өдрөөс хойш хоёр долоо хоногийн дотор хянаж, монгол хэлний төвшин тогтоох шалгалтыг Монгол хэлний мэргэжлийн тэнхимтэй хамтран цахим хэлбэрээр зохион байгуулж, суралцуулах эсэх тухай саналаа Сургалтын нэгдсэн албанд ирүүлнэ.
- 4.3. Сургалтын нэгдсэн албад ирүүлсэн саналыг нягтлан, шаардлага хангасан гадаадын иргэнд суралцах зөвшөөрөл олгохыг Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ)-наас хүснэ. Улмаар БШУЯ-наас суралцах зөвшөөрөл, виз мэдүүлэхийг зөвшөөрсөн албан бичиг олгосон гадаадын иргэнд МУИС-д суралцах эрхийн бичгийг и-мэйл, факс, шуудангаар илгээнэ. Захидалд Монгол улсад суралцах виз авахын тулд ямар бичиг баримт бүрдүүлэн, хаана, хэнд, ямар хугацаанд багтан хандах тухай, сургалт эхлэхээс өмнө эхний улирлын сургалтын төлбөр төлсөн байх тухай, мөн монгол хэлний бэлтгэл хөтөлбөрт суралцахаар хүсэлт гаргасан гадаадын иргэдээс монгол хэлний түвшин тогтоох шалгалт авах өдөр, цаг, газрыг заавал дурьдсан байна. МУИС-д суралцах эрх нь дараалсан хоёр хичээлийн жилд хүчинтэй.
- 4.4. Монгол хэлний бэлтгэл хөтөлбөрт суралцах гадаадын иргэний монгол хэлний түвшин тогтоох шалгалтыг тухайн улирлын хичээл эхлэхээс долоо хоногийн өмнө Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим зохион байгуулна. Монгол хэлний түвшин тогтоох шалгалтыг гадаадын иргэн биеэрээ ирж өгнө. Шалгалтаар тухайн гадаадын иргэн ямар түвшний Монгол хэлний бэлтгэл хөтөлбөрт хамрагдах шаардлагатайг тогтооно.
- 4.5. МУИС-д суралцах эрх авсан гадаадын иргэн сургалтын нэгдсэн албанаас Монгол улсад суралцах визийн холбогдолтой асуудлаар зөвөлгөө авч болно.
- 4.6. МУИС-д мэргэжил дээшлүүлэх, судлаачаар ажиллах хүсэлтэй гадаадын иргэдийн өргөдөлд Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс бүрэлдэхүүн сургуулиудын захиргаатай зөвшилцсөний үндсэн дээр тухайн улирлын хичээл эхлэхээс 2-оос доошгүй сарын өмнө хариу өгч, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

#### **5. Сургалттай холбоотой төлбөр, хураамж**

- 5.1. Гадаад оюутны судлах хичээлийн багц цагийн төлбөр, улирлын суурь хураамжийн хэмжээ болон МУИС-д мэргэжил дээшлүүлэх, судлаачаар ажиллах хүсэлтэй гадаадын иргэдийн төлөх төлбөрийн хэмжээг жил бүр шинэчлэн тогтоож МУИС-ийн Удирдах зөвлөл батлах ба тухайн хичээлийн жилийн хугацаанд өөрчлөхгүй. Сургалтын төлбөрийг оюутан улирал бүр төлнө.
- 5.2. Амьдрах, суралцахтай холбоотой төлбөр хураамж, тухайлбал оюутны байрны төлбөр, хураамж, ном сурах бичгийн зардлыг оюутан өөрөө хариуцна.
- 5.3. Хоёр улсын Засгийн газар хоорондын болон хоёр тал /МУИС ба гадаадын байгууллага, иргэн/-ын гэрээ, хэлэлцээрийн дагуу суралцах, мэргэжил дээшлүүлэх, судлаачаар ажиллах гадаадын иргэдийн сургалтын төлбөр болон амьдрах зардлыг гэрээнд заасны дагуу шийдвэрлэнэ.
- 5.4. МУИС-д суралцах эрх авсан гадаадын иргэн амь насны, эрүүл мэндийн болон гэнэтийн ослын даатгалыг эх орондоо эсвэл Монгол улсад ирсэн хойноо өөрөө эсвэл хүсэлт гарган МУИС-ийн сургалтын нэгдсэн алба, бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албаны дэмжлэгтэй хийлгэнэ.

- 5.5. Суралцах явцдаа зохих шалгуур хангасан оюутан МУИС-иас гадаад оюутанд зориулсан тэтгэлэгт хамрагдах боломжтой.

## **6. Бусад**

- 6.1. МУИС-д элсэх эрх авсан гадаадын иргэн тухайн улирал эхлэхээс 7-14 хоногийн өмнө бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанд биеэрээ ирж бүртгүүлж, МУИС-ийн сургалтын мэдээллийн систем ашиглах хэрэглэгчийн нэр, нууц үгийг авна.
- 6.2. Бүртгүүлсэн гадаадын иргэн тухайн улиралд судлах хичээлээ сонгон баталгаажуулсны дараа элссэн тухай МУИС-ийн захирлын тушаалыг гаргана. .
- 6.3. МУИС-ийн оюутан болсон гадаадын иргэн Монгол улсын харьяат оюутны нэгэн адил дүрэм, журмаар суралцана.
- 6.4. Элсэлтэй холбоотой бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн тохиолдолд МУИС-д элсүүлэхгүй ба элссэн тохиолдолд хасна.
- 6.5. Элсэлтийг цахим хэлбэрээр явуулахад зориулсан цахим хуудас нь бүтэн жилийн турш тогтмол ажиллагаатай байж элсэлтийн талаарх мэдээллээр бүртгүүлэгчдийг хангана.
- 6.6. Цахим бүртгэл явагдаж байх үед МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиуд хөтөлбөрүүдээ танилцуулах, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг утас, мессенжер болон цахим шуудангаар зохион байгуулна.
- 6.7. МУИС-д суралцах эрх авсан гадаадын иргэн хүндэтгэх шалтгаанаар хичээлийн жилийн тухайн улирлын эхний хоёр долоо хоногт багтаж суралцахаар ирвэл элссэн тухай тушаал гарган, тухайн улирлын хичээлийг судлах эрх өгөх ба дурдсан хугацаанаас хойш ирвэл дараагийн улирлын эхнээс хичээл судлах эрх олгоно.
- 6.8. МУИС-д суралцаж буй гадаадын иргэн суралцах явцдаа иргэний харьяалалаа сольж, Монгол улсын харьяат иргэн болвол албан ёсоор Монгол улсын иргэн болсон өдрөөс нь гадаад оюутны статусыг нь цуцална. Сургалтын төлбөрийг дараагийн хичээлийн жилээс эхлэн Монгол улсын иргэнтэй адил хэмжээтэй тогтооно.
- 6.9. Монголын бусад их сургуулиас МУИС-д болон МУИС-ийн хөтөлбөр хооронд шилжин суралцах хүсэлтэй гадаадын иргэний хүсэлтийг бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын алба хүлээн авч МУИС-д Оюутан шилжүүлэн суралцуулах журмын дагуу шийдвэрлүүлнэ.
- 6.10. Гадаад иргэний МУИС-д элсэн суралцах хүсэлт шийдвэрлэгдсэнээс хойшхи Монгол улсад ирэх, оршин суухтай холбоотой асуудлууд болон нийгэм, соёл, хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба, сургалтын нэгдсэн алба хариуцна.
- 6.11. Оюутны суралцах хугацаа, тэтгэлэг, сургалтын болон бусад төлбөрийн хэмжээ, орон байр, эрүүл мэнд, даатгалын асуудал болон шаардлагатай бусад асуудлыг бүрэлдэхүүн сургуулийн захирал, сургалтын алба, суралцагч, хоорондын гурвалсан гэрээгээр зохицуулна.
- 6.12. Монгол хэлний бэлтгэл хөтөлбөрийн бүрэн болон бүрэн бус курсыг төгссөн оюутанд МУИС-ийн Захирлын тушаалаар гэрчилгээ олгоно.
- 6.13. МУИС-д суралцаж буй гадаадын иргэн Монгол улсын үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан гадаадын иргэний эрх зүйн байдлын талаарх хууль тогтоомж, сургуулийн дүрэм, журмыг чанд мөрдөнө.
- 6.14. МУИС-д өмнө нь суралцаж байсан боловч Монгол улсын хууль тогтоомж, МУИС-ийн дүрэм, журмыг зөрчиж сургуулиас хасагдсан гадаадын иргэн МУИС-д дахин суралцах боломжгүй.